

Хууль төрөхийн өмнө



ОЛНЫ САНАА ОНЧТОЙ МЭРГЭН

Монгол Улсын Үндсэн хуулиар “Иргэн төр, засгийн газрын мэдээллийг олж авах чадвартай байх” ардчиллын үндсэн зарчмын нэгийг бүрнээ баталгаажуулжээ. Үүнийг төрийн эрх мэдэл ард түмний мэдэлд байх, ард түмэн өөрийнх нь сонгосон байгууллага хэрхэн ажиллаж байгаа, тэдний эрх ашгийг төлөөлж чадаж буй эсэхийг мэдэхийг хүсвэл төр, засгийн байгууллага, түүний албан тушаалтнаас энэ тухай мэдээлэл авахыг шаардах эрхтэй хэмээн ойлгож болно. Бид өөрсдөө ардчилсан сонгуулиар төр засгаа бүрдүүлж, тэдэнд өөрсдийн аз жаргалтай, сэтгэл хангалуун, элбэг баян амьдрах хамгийн таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх үүрэг ноогдуулдаг. Учир нь тэд энэ бүхнийг амлаж гарч ирсэн, нөгөө талаар төр, засгийн газар, түүний бүтцийн байгууллагуудыг бид хувийнхаа халааснаас санхүүжүүлдэг. Иймээс төр засаг амласнаа хэр биелүүлж байна, бидний мөнгийг хэр үр ашигтай зарцуулж байна гэдэгт хяналт тавих хууль ёсны эрхтэй. Үүнийг “Олон нийтийн мэдэх эрх” ойлгож болно.

Мэдэх эрх нь хүний амьдрах эрхтэй салшгүй холбоотой. Хэрэв хүн нийгэмдээ болж буй үйл явдлыг мэдэхгүй, эсвэл удирдагчдынх нь үйл ажиллагаа нуугдмал байх аваас нийгмийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулж чадахгүй, иргэдийн амьдрал ч дээшлэхгүй.

Мэдээллийг ардчиллын хүчил төрөгч гэдэг. Ардчиллыг бэхжүүлэхэд мэдээллийн эрх чөлөө хамгийн чухал үүрэг гүйцэтгэнэ. Мэдээлэл нь зөвхөн хүмүүст хэрэгтэй зүйл төдийгүй, мөн шилдэг, шударга сайн засаглалын амин чухал салшгүй бүрэлдэхүүн хэсэг юм. Мэдээлэлгүйгээр төр засаг зөв шийдвэр гаргах боломжгүй. Харин нууцлаг байдал нь авилгыг тэжээн тэтгэх үндэс суурь болж, эрх мэдлээ буруугаар ашиглахад, мөн удирдлагын алдаатай үйл ажиллагаанд хүргэдэг байна. Мэдээлэл олж авах эрхийг баталгаажуулах нь төр засгийн үйл ажиллагаанд ч тустай. Нобелийн шагналт эдийн засагч Амарта Сений судалснаар ардчилсан засгийн газартай, харьцангуй чөлөөт хэвлэлтэй оронд хэзээ ч нийтийг хамарсан өлсгөлөн гарч байгаагүй гэдэг.

Мэдээлэлтэй байх нь:

Ардчилсан төр засгаа бүрдүүлэхэд нэр дэвшигчдийн талаар бодитой мэдээлэлтэй байж зөв хүнээ сонгож, зохих ёсоор сонгуульд саналаа өгөх,

Олон нийтэд төр засгийн үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага тооцох боломж олгох,

Мэдээллийг чөлөөтэй олж авснаар өөрийнхөө үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлж, өөрсдийн амьдралыг хөндсөн шийдвэр гаргахад оролцох, нөлөөлөх боломжтой болно.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 59 дүгээр чуулганаар “Мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх бөгөөд бүх эрхэм эрх чөлөөний тулгуур чулуу мөн” гэж тунхагласан. Хэрэв мэдээллийн эрх чөлөө нь хүний үндсэн эрх юм бол бусад эрх нь түүнээс хамааралтай байх ба энэ эрхийг баталгаажуулахгүйгээр хүний эрхийг хамгаалах бүх систем зүй ёсоор ажиллаж чадахгүй нь тодорхой.

“Глоб Интернэшнл” ТББ 2001 оноос Мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, үзэл баримтлал, зарчмыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр өргөн хүрээнд ажил хийсэн юм. Эхэн үедээ мэдээллийн эрх чөлөө гэдгийг олон нийт, ялангуяа эрх баригчид хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй юм уу, эсвэл шар хэвлэлтэй холбоотой мэтээр өрөөсгөл ойлгох нь түгээмэл байсан бол одоо мэдээлэл гэж юу юм бэ, хэвлэл мэдээллийн эрх чөлөөнөөс юугаараа ялгаатай юм гэдгийг хүмүүс ялгаж, салган ойлгодог болжээ. Өөрөөр хэлбэл, бид мэдээлэлгүй байснаараа өөрсдөө “хохирогч” болдог гэдгийг ухамсарлан, үүний төлөө идэвхтэй ярьж, бичиж, зарим нь тэмцэж эхэлсэн нь нэг талаар бидний ажлын үр дүнгийн илрэл хэмээн ойлгодог.

Мэдээллийг хайх, олж авах, хүлээн авах, түгээх гэсэн эрхийг багцаар нь мэдээллийн эрх чөлөө хэмээн томъёолдог. Мэдээлэл нээлттэй, чөлөөтэй, хүлээн авахад хялбар байх ёстой. Харин өнөөдөр Монгол Улсад иргэд төр засгийн болон хувийн аль ч байгууллагаас хүссэн мэдээллээ олж авах бололцоо тэр бүр алга байна. Энэ нь ялангуяа сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын олон нийтийн өмнө “тэдний ашиг сонирхолд нийцсэн мэдээлэл түгээх”-ээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд хамгийн их саад бэрхшээл учруулж байгаа юм. Өнөөдөр төр засгийн байгууллага, албан тушаалтны зарим нь үйл ажиллагаагаа олон нийтийн нүднээс далдуур нууцаар явуулах эрмэлзлэлтэй байгаа мэт эргэлзээг төрүүлж байна. Харамсалтай нь засгийн газар ард түмнийг төлөөлж албан ёсны мэдээллийг хадгалж байгаа гэж үзэхээсээ илүүтэйгээр өөрсдийн эрх мэдэлд байгаа мэдээлэлд өөрсдийн өмч мэт үздэг хандлага юм.

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт



ГОЁ НЭРЭНДЭЭ ЦАТГАЛДСАН НҮЦГЭН ЭРХ ЧӨЛӨӨ

ЧОНЫН АМНААС БАРЫН АМАНД

Саяхан тэмдэглэсэн олон улсын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний өдөр миний сэтгэлийг загатнуулж, үг өдлөө. Би өөртэйгөө ярьж байна. Өөрийнхөө оюун сэтгэлийг гүүр болгон дэвсэж уншигч авгай нарын сэтгэлд дөхөж очихоор тэмцэж явна.

Бодвоос “Хэвлэл мэдээллийн эрх чөлөө” хэмээх хэллэг нь хамгийн олон хүний амнаас уянгалан унаж байдаг аялгуу сайхан монгол үгс юм байна. Харин тэр нь байгаа амьдрал уу эсвэл байхгүй амьдралын мөрөөдөл үү? Ямар хариулт уншигч таны оюунд тусч байгааг үл мэднэ. Харин минийхийг сонирхвол сүүлчийнх нь. Манайд социализмын үед ганцхан МАХН-ын мэдэлд бүх хэвлэлүүд захирагдаж байсан гэж шүүмжилдэг. Энэ гарцаагүй үнэн, бүгдээрээ ганц хэцүү чонын аманд зуулттай байсан гэсэн үг. Одоо тэрхүү ганц чонынхоо амнаас хэдүйнэ мултарч амжсан. Гай газар дороос гэгчээр хэвлэлийн зовлон үүгээр дууссангүй. Чонын амнаас барын аманд орох үйлтэй байж. Зүйрлэхэд олон барс ирвэс монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн дийлэнхийг хуваагаад зуучихсан байна. Нийтийн өмч байх учиртай нийгмийн мэдээлэл чөөн эздийн хувийн өмч болов.

САМСАА ШАРЛАХ ЗОВЛОН.

Сэтгүүлчийг танихад амархан, сайн ажвал оюун санаа нь цаанаа л нэг шарлангуй явдаг юм. Хуучуулын ярьдгаар нэгэн бол гутал нь хавчсан, эсвэл олон эхнэртэй хүн шар самсаатай явдаг гэсэн. Хэвлэлийнхний зовлон түүнтэй төстэй. Харьяалах ил далд эздийнх нь ухаан санаа бариу гутал шиг бачуурч өөр өөр рүүгээ татаж чангаагаад ирэхийн цагт төр засгийн удирдлагуудыг хянан цагдаж, ном дүрмээр нь залж явах тэнгэрийн томиллолт өвөрлөсөн гэх сэтгүүлчдийн маань ухаан санаа олон эхнэртэй юм шиг хэдэн тийшээ тэлэгдэж хаашаа ч үгүй хоолойд тээглэсэн яс шиг гацах удаа олоон.

ХААНТАЙ УРАЛДАХ УУ, БАЙХ УУ?.

Хаантай уралдвал хаанаасаа түрүүлж болохгүй. Бас санаатай хоцорч болохгүй. Тэгэхээр хаантайгаа уралдах нь осолтой спорт. Сэтгүүлчдэд ийм явдал бас тааралдаад байдаг. Олон янзын чиглэл баримжааны хэдэн арав, зуун улс төрчид, бизнесмэн, сайд дарга нарын дундаас өөрийн бор ходоодыг тэжээх хэдэн гурван мөнгө ахиухан өгдөг тэр зүгийн дээдэст таалагдах хэмжээгээр л авьяас чадвараа аргамжиж явахгүй бол, ажил албагүй гудамж метрлүүлнэ шүү гэсэн үггүй сүрдүүлэг сэтгүүлчдийг мөрдөж байх боллоо. Тийм болохоор эрин цагаас түрүүлсэн ч гэмээр сэтгүүлч нөхдийн сайхан сайхан санаа, сэдлүүд нь улс төрчдийн ойворгон хийрхэлд хучигдан, өнгө жавхаа нь бүдгэрэн замхраад, заримдаа түүнийхээ төлөө бусдын өмнөөс муу нэр дуулаад өнгөрдөг жишээний. Ингээд л улс төрч том бага хаадын хувийн сэтгүүлч болох аялал эхлэв үү дээ.

БӨӨСӨНД ХУТГА ГАРГАДАГҮЙ ЭЭ

Гаднын хүнд төдийлөн анзаарагддаггүй нэг хэцүү зовлон бий, сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэнд. Түүнийг хувийн эрх чөлөө байхгүйн зовлон гэж болох. Зүйрлэвэл авдар дүүрэн мөнгөний түлхүүр өвөртөлж явавч хөл муутай хөгшин аавдаа ганц таяг аваад өгөх мэдэл албаны мөнгөний няравт байдаггүйтэй адилхан бэрхшээл тэдэнд бий. Доголон эцгийгээ таягтай болгохын тулд тэр өөрөө мөнгө ба мөнгөө зарах мэдэлтэй байх ёстой. Тэр цагт эцгийгээ өрөвдөн хайрлах сэтгэл нь түүний ухааныг захиран таяг авахуулна. Энэ тохиолдолд мөнөөх нярав нь нярав биш, хувийн эрх чөлөөтэй иргэн болж түүнийгээ эдэлж байна.

Хөлсний сэтгүүлчдэд албаны мөнгөний нярав шиг хувийн эрх чөлөө дутагдснаас шүүмжлэхийгээ магтаж, магтахыгаа шүүмжлэх тохиолдол олон. Уг чанартаа аргагүйн эрхэнд өөрөөсөө урваж байгаа дэндүү гунигтай явдал. Хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэдгээс гадна сэтгүүлчийн эрх чөлөө гэж нэг том асуудал байдгийг санамаар байна. Жинхэнэ эрх чөлөөтэй сэтгүүлч л үнэнийг бичиж чадна. Хамгийн харамсалтай нь манайд сэтгүүлчийн эрх чөлөө нь юуны өмнө мөнгөнд хүлэгдчихэв ээ. Яг л үнэн юм яриад байх шиг харагдавч ар тал дахь амьдралаа бодон мөнгө зүүдлэн бичих тохиолдол байна. Ийм байдалд хүрчихсэн эрх чөлөөгүй хөлсний хэдэн сэтгүүлчдийг шоронд хорьж, ял эдлүүлэх нь үнэндээ бөөсөнд хуга гаргахтай адил эзнийг нь олоогүй сүржигнүүр явдал. Харин буруутай нь нотлогдсон бол сэтгүүлчдийн хөдөлмөрийг ашиглаж байгаа эздийг л хариуцлагад татаж байх ёстой. Зуд ирвэл хамгийн түрүүнд зуд даахгүй давжаа үр төл гаргасных нь төлөө хуц ухныг нь аваад явчихдаг байгаль ээжээсээ үлгэр авахад яагаад болохгүй гэж.

ХОДООДНЫ ДУРШИЛ

Тархи хэмээх ухаан, зүрх хэмээх сэтгэл хоёрын халз тулаанд зүрх ялагдахаар хүн өөрөөсөө урвадаг. Мөнгө ба эрх мэдэлд шунаснаас, бас тогтмол ажилтай байхын тулд сэтгүүлчдийн ухаан нь зүрх сэтгэлээ дийлж өөрийнхөө төрөлх чанарын эсрэг нийтлэл бичүүлэх нь бий. Ийм тохиолдлыг “Ходоодны дуршилтай” практик сэтгүүл зүй гэж нэрлэхнээ ч болох. Ингэх нь зөвхөн хөлсний сэтгүүлчдийн үйлддэг нүгэл биш. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн (19 дүгээр зууны эцсээр худал нийтлэлээрээ АНУ, Испаний хооронд дайн өдөөж 500 сая долларын ашиг олсон У.Хёрст шиг) эзэд ийм нүгэл үйлддэг.

Ер нь үнэний дуршилтай хэвлэл мэдээлэл ингэж ходоодны (эд мөнгөний) дуршилтай болно гэдэг чинь нийгэм бүхэлдээ аливаа асуудлыг зөвхөн ходоодныхоо заавраар сонгодог болохын цондон. Асуудал даамжрах аваас монголд төр түмэн байтугай төрсөн эцэг хүү хоёр хоорондоо таарч тохироход хэцүү болно. Үнэний төлөө сэтгүүл зүйг зоосны сэтгүүл зүй болгочихгүйн тулд юуны өмнө хэвлэл мэдээллийн ажилтнуудын шударга хөдөлмөрийн үнэлгээг дээшлүүлж хэдхэн халтар төгрөгний төлөө мэргэжлээ худалдаж

Хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эхсүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эхсүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтана (Иргэний болон Улс төрийн тухай Олон Улсын Пакт, 19 дүгээр зүйл, 2 дахь хэсэг).



ЦЕНЗУР БА МОНГОЛЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ

Монголын Нээлттэй Нийгэм Форум, “Глоб Интернэшнл” ТББ-тай хамтран Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөрт зориулсан дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулж байгаад гүн талархал илэрхийлье!

Монгол Улс 17 жилийн өмнө чөлөөт хэвлэлийн анхны эх үүсвэрийг тавихдаа өнөөдрийн өдрийг хүртэл чухам юу юу тохиолдох вэ? гэдгийг бүрэн төсөөлж чадаагүй, тэгэх бололцоо байгаагүй. Ардчилал, зах зээлийн тогтолцоонд ихэнх ард иргэд бэлэн байгаагүй шиг, хэвлэл мэдээллийн салбар, тэнд ажиллагсад ч цоо шинэ мөртөө, адармаатай, бэрхшээлтэй замыг туулсаар өнөөдрийг хүрлээ. Бидэнд олсон ололт бий. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл төрийн өмчөөс бараг 100% салж, 1990 оноос өмнөх главлитын үеийг бодвол хэлэх гэсэнээ хэлж, нийтлүүлье гэсэнээ нийтлүүлэх боломжтой болсон. Редакц ч өөрцгүй харьцангуй бие даасан байгаа. Барууны сэтгүүл зүйн хэв маяг алгуур боловч нэвтэрсээр байна. Гэхдээ Монголын сэтгүүл зүйн нөхцөл байдал өнөөдөр тийм ч сайнгүй, зарим талаар түгшүүр төрүүлэхүйц хэмжээнд байгааг бид хүлээн зөвшөөрөх ёстой. Үүнээс гадна өмнө сэтгүүлчдийн үндсэн үүрэг болсон үнэн бодит мэдээллийг түгээх бололцоог янз бүрийн байдлаар алдагдуулж буйг нэрлэх ёстой. Өөрөөр хэлбэл, Монголын сэтгүүлчид айдас түгшүүрийн дор, амиа хоохойлохын эрхэнд, аялдан дагалдахын орчинд ажиллацгааж байна. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө нь ардчилсан нийгмийн салшгүй хэсэг бөгөөд энэхүү эрх чөлөөний баталгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хэрэгжиж, хэвлэлийн эрх чөлөөг бодит болгодог, энэхүү иргэн хүн үгээ хэлж, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг дэлхий нийтээр зөвшөөрөн дагаж буйг энэ эрхэнд нь шууд болон шууд бусаар хориг хязгаар тавьдаг цөөнгүй улс одоо бий бөгөөд дээрх үйлдлийг цензур буюу цагдан хяналт хэмээн нэрийдэж байна.

Монгол Улсад цагдан хяналтыг 1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар хориглосон ч амьдрал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх зөрчигдсөөр байна. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх ийнхүү зөрчигдөх нь

хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчид үнэн мэдээлэл түгээж чадахгүйд хүрч, ардчилал, нийгмийн эрх ашигт бодит хохирол учруулсаар байна.

Цагдан хяналт олон хэлбэрээр илэрдэг талаар судлаачид тэмдэглэсэн байдаг. Хамгийн эхний хэлбэр нь шууд хяналт, хориг тавих явдал. Сонин хэвлэлийг хаах, айлган сүрдүүлэх, шорон гянданд хорих, бүр сэтгүүлчийн амь насыг бүрэлгэх хэлбэрээр илэрдэг. Ийм төрлийн жишээ манайд өмнө нь тодорхой хүрээнд гарч байсныг та бүхэн санаж байгаа байх. Гэхдээ энэхүү хэлбэр өнөөдөр төдийлөн түгээмэл биш гэдгийг хэлэх хэрэгтэй.

Цензурын дараагийн хэлбэр бол яах аргагүй далд хэлбэр. Далд хэлбэрийг улс төрийн, төрийн, захиргааны, эдийн засгийн, редакцийн, өөрийн цензур гэх мэт хэд хэдэн хэв шинжээр хуваан үзэж болмоор. Тухайлбал, эрх баригчид өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан шударга шүүмжлэлийг няцаах, өөрсдийн буруутай үйлдлийг олон түмнээс нуун дарагдуулахын тулд янз бүрийн мэдэгдэл гаргаж, олон нийтийн дунд төөрөгдөл, буруу ойлголт өгөх явдал байсаар байна. Өөрөөр хэлбэл, улс төрийн цензурын ийм хэлбэр манайд байна.

Төрийн цензур нь хуулиар дамжин хэрэгждэг. Ялангуяа улс төрч, эрх баригчид нэр төр, алдар хүнд, гүтгэлэгтэй холбоотой эрүүгийн хуулийн хатуу заалтуудыг цензур болгон өргөнөөр хэрэглэж байна.

Захиргааны цензурын сонгодог жишээ нь ажил үүргээ гүйцэтгэж буй сэтгүүлчдийг албан газарт оруулахгүй байх, ялгаварлан гадуурхах, мэдээлэл өгөхөөс татгалзах, саад тотгор үзүүлэх зэрэг өдөр тутам тохиолддог үйлдлээр илэрч байна.

Далд цензурын хамгийн их анхаарал татахуйц, өнөөдөр нилээд түгээмэл болсон хэлбэр нь эдийн засгийн цензур гэж хэлж болох юм. 1990-ээд оны эхэн үед энэ хэлбэрт цензур нь одоогийнхоос арай өөрөөр илэрч байсныг та бүхэн санаж байгаа байх. Нэг намын хяналтанд байх үедээ хэвлэх үйлдвэрийг монопольчлох, зарлан сурталчлах эрхийг төрийн төв хэвлэлүүдэд өгөх, мөн өндөр татвараар чөлөөт



НЭР ТӨР, АЛДАР ХҮНД, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХАД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ

Хүний хамгийн нандин эрх, эрх чөлөөний илэрхийлэл болсон үг хэлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг Монгол Улс шинэ үндсэн хуулиараа баталгаажуулснаас хойш даруй 15 жилийг ардаар орхижээ. Эрх чөлөө, тэр тусмаа хэвлэлийн эрх чөлөө бол ардчиллын амин сүнс гэдэгтэй хэн ч маргадаггүй. Өнгөрсөн он жилүүдэд улс орон маань хөгжлийн зөв замдаа шуударч, хүн болгон шударга ариун хөдөлмөрөөрөө сайхан амьдралд хүрэх боломж илүү нээлттэй болсон. Харамсалтай нь шударга бус явдал, улс төр, өнгө мөнгөний хуйвалдаан, авилга, дарангуйлал нийгэмд хүрээ хязгаараа тэлсээр байгаа нь бас бодит үнэн. Нийгмийг өвчлүүлэн, олон түмний эрх ашгийг хөсөрдүүлж байгаа тэр бохир орчинг эрүүлжүүлэн, цэвэршүүлэх амаргүй атлаа ариун шударга үүргийг манай сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд өөртөө хүлээж байдаг билээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь ардчилал, нээлттэй нийгмийн нэг тулгуур багана бөгөөд хүний эрх, шударга ёс, хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулах нь нээлттэй нийгэм дэх хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааны нэг гол шинж юм.

Харин хэвлэл мэдээллийн хэрэгслээр бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харшлах мэдээ, сэлт нийгэмд тараах, хууль зөрчих нь Монголын нийгэмд өнөө үед гарч буй гэмт хэрэг, зөрчлийн дотор ялимгүй хувийг эзэлдэг ч судалгаанаас үзэхэд бусдын нэр төр, алдар хүндийг гутаасан хэрэг, маргаан цаашид буурахгүй өсөх хандлагатай байна. Энэ нь чөлөөт хэвлэлийн үүрэг, ач холбогдлыг бууруулж, дөрөв дэх засаглалын эрх мэдлийн нийгмийн хүч, нөлөөг сулруулахад хүргэж болзошгүй ноцтой үр дагавартайг анхаарууштай.

Хүний нэр төр, алдар хүндтэй холбогдсон хэрэг маргаанд хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид хамгийн ихээр холбогддог. Тухайлбал, 1991-2001 оны 10-р дугаар сарыг дуустлах 10 жил 10 сарын хугацаанд гарсан энэ төрлийн хэрэг, маргааны талаарх тоог дараахь хүснэгтэд үзүүлэв.

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999	2000	2001.10	Нийт хэрэг
Иргэний хэрэг	7	5	5	5	8	13	27	31	30	39	10	174
Эрүүгийн хэрэг									3		1	4
Дүн	7	5	5	5	8	13	23	31	33	39	11	178

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг талаар бусдын нэр төрийг гутаах, нөгөө талаар нэр төрөө шүүхээр

сэргээлгэх явдал 1995 оноос 2000 он хүртэл жил дараалан өсч, 1996 онд 13, 1997 онд 23, 1998 онд 31, 1999 онд 33, 2000 онд 39 болж өссөн байна. Мөн энэ төрлийн хэрэг, маргааны тоо өсөж байна гэж үзэх үндэсгүй талаар Улсын Дээд Шүүхийн судалгаанд ч тусгагдсан байна.

Нэр төрөө сэргээлгэхээр нэхэмжлэл гаргагчдын байдлыг судалж үзэхэд ихэвчлэн алдар цуутай хүмүүс, улс төрийн өндөр албан тушаалтнууд эзэлж байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан болон бусдыг гүтгэсэн тухай нийслэлийн хэмжээнд 1999 оноос 2001 оны 11-р сарын 1-нийг хүртэл шүүхээр хянан шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны талаар судлан зохих дүгнэлт хийж тайлан боловсруулах зорилгоор 2001 оны 11-р сард Монгол дахь Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн санхүүжилтээр Монгол Улсын гавьяат хуульч Б.Чимидийн удирдлага дор төслийн судалгааг хийсэн байна.

Уг судалгаагаар нийслэлийн 6 дүүргийн шүүхээр хянан шийдвэрлэсэн иргэний болон эрүүгийн хэрэг, тэдгээрийг үйлдсэн агуулга, үүссэн шалтгаан, бүрэлдэхүүний байдал, сэтгүүлчид эрхээ хамгаалах механизмыг хэрхэн ашигласан тухай, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх асуудлаар шүүгчид, хууль зүйн зөвлөгөө өгөх чиглэлээр өмгөөлөгчдийг мэргэшүүлэх шаардлага зэрэг асуудлыг эмпирик болон харьцуулсан судалгааны аргаар шинжлэн судалгааны тайлан боловсруулжээ. Судалгаагаар нийслэлийн зургаан дүүргийн шүүхэд дээрх 3 жилийн байдлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр хувь хүн, хуулийн этгээдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан тухай иргэний маргаан 79, гүтгэлгийг хэвлэлд нийтлэх буюу бусад аргаар олшруулан тараасан гэмт хэрэг 4 бүгд 83 хэрэг, маргаан хянан шийдвэрлэгдсэн байна.

Энэхүү 79 иргэний хэргийн 47 хэрэгт шүүх хариуцагчаар татагдан орсон хэвлэл мэдээллийн хэрэгслийг бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хэвлэлээр дамжуулан гутаасан гэм буруутай гэж тогтоожээ. Энэ нь нийт иргэний хэргийн 59.9 хувь байх бөгөөд эдгээр хэргийн 29.1 хувь буюу 23 хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутайгаа хүлээн зөвшөөрч эвлэрсэн байна.

Дурьдсан хугацаанд гарсан энэ төрлийн нийт 79 иргэний хэрэг маргааны 70-д нь буюу 88.6 хувьд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруутайд тооцогдсон байна.

Харин дээрх 79 иргэний хэрэг маргааны 5.1 хувь буюу зөвхөн 4 хэрэгт хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэм буруугүй, өөрөөр хэлбэл, нийтлэл нь бусдын нэр төрийг гутаагаагүй байна гэж шүүх тогтоосныг үзвэл хэвлэл мэдээллийн хэрэгсэл хүний эрх, ашиг сонирхлыг хөсөрдүүлдэг гэсэн дүгнэлт хийхэд хүргэсэн байна.

Европын Хүний эрхийн шүүх “түүнчлэн Засгийн газар, албан байгууллага, албан тушаалтныг шүүмжилсний төлөө шоронд суулгах нь Европын зөвлөлийн гишүүдийн хувьд үл нийцэх, хүлээн зөвшөөрч болохгүй зүйл” гэдгийг тодотгосон байна. Энэ баримт бичгүүдэд Монгол улс өнөө нэгдээгүй ч олон улсын жишиг юм. Сүүлийн 10 гаруй жилд Европын орнуудаас гүтгэлгийн хэргээр нэг ч хүн хорих болон баривчлах ялаар шийтгүүлээгүй байна.

Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолын тухай заалт хүний эрхийг хамгаалахад чиглэгдсэн боловч, эрх баригчид албан тушаалтан, төр засгийн байгууллагын талаар шүүмжлэлт материал нийтлүүлсэн сэтгүүлчдийн эсрэг ашиглах оролдлого гарсаар байна. Амьдрал дээр ийм байдал цөөнгүй ажиглагдах боллоо. Аливаа шүүмжлэгдсэн этгээд өөрийгөө гүтгүүлэн доромжлогдсон гэж үзэн цагдаа, прокурорын байгууллагад гомдлоо гаргаж, шүүхэд хандан хэрэг үүсгүүлэх боломж улам ч өргөжсөөр байна. Энэ нь ардчилсан нийгэм дэх хэвлэл мэдээллийн олон нийтийн өмнө хүлээсэн үүргийн дагуу авилга, гэмт хэрэг, хүний эрхийн зөрчил зэрэг аливаа нуугдмал бугшмал баримт сэлтийг сурвалжлан илрүүлэх, эрэн сурвалжилж олон нийтэд дэлгэн тавих шүүмжлэлт сэтгүүл зүйн зарчимд харшилж, сэтгүүлчдийн мэргэжлийн эрхээ эдлэх боломжийг хязгаарлахад зарим талаараа хүрээд байна гэсэн дүгнэлтийг хийж болох юм.

Сэтгүүлчдийг бичсэн нийтлэлийнх нь төлөө эрүүгийн хуулиар шийтгэснээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэд ямар ч хариуцлага хүлээхгүй ард нь үлдэж жирийн сэтгүүлч нь золиослогдох явдал ч ажиглагдах болов.

Манай улсын гүтгэлэг, доромжлол нэр төртэй холбоотой хуулийн заалтуудад мэдээллийг няцааж эрхийг баталгаажуулаагүй, нэр төрд нь халдсан мэдээллийг худал, хортой, буруу болохыг нотлох тухай тодорхой заалт ч алга байна.

Нэр төрөө сэргээлгэхээр гаргасан нэхэмжлэлийн хариуд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллага тухайн хэргийг үнэн бодитойгоор шударга ёс, олон нийтийн эрх ашгийн төлөө сурвалжилсан, шударга тайлбар өгсөн зэрэг үндэслэлээр өөрийгөө өмгөөлөхийг зөвшөөрөх нь олон улсын жишигт бүрэн нийцнэ.

Ардчилсан нийгэмд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө баталгаажсан байх ёстой ч, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хамгаалах үүднээс шаардлагатай хязгаарлалтуудыг нарийвчлан тусгаж өгөх нь 2000 оны 2 дугаар сарын 29-өөс 3 дугаар сарын 1-ий өдрүүдэд Лондон хотноо зохиогдсон “Гүтгэлгийн эсрэг хууль”-ийн талаархи семинарын гол зарчим байсан байна. Гүтгэлгийн эсрэг хуулийн гол зорилго нь нэр хүндээ бууруулж хохирсон иргэн нэхэмжлэл гаргах эрхтэй ч, албан хаагчийн буруутай үйл ажиллагааг зүй ёсоор шүүмжилсэн, хээл хахуулийг ил гаргасан тохиолдолд гүтгэлгийн эсрэг хууль хэрэглэхийг хоригложээ. Түүнчлэн зарчмын хувьд эрүүгийн хуулиас гүтгэлгийн эсрэг заалтыг хасч, иргэний хуулиар зохицуулах хэрэгтэйг гүтгэлгийн эсрэг заалтуудыг эрүүгийн хуулиндаа хэрэглэж байгаа орнуудад зориуд анхааруулжээ.

Гүтгэгдсэн гэх тал өндөр байр суурьтай, өөрөөр хэлбэл, төр засгийн албан тушаалтан байсан ч тэдний

өмнөөс гүтгэлгийн эсрэг хэрэг үүсгүүлэхээр хэн нэгэн санаачлага гаргасан бол түүнийг хүлээж авахгүй байх. Хорих, сэтгүүл зүйн эрхийг нь хасах, хэт их торгууль тавих буюу эрүүгийн хатуу ял шийтгэл хариуцлагыг гүтгэлгийн гэмт хэргийн субъектэд оногдуулахгүй байх өөрчлөлтийг ч манай холбогдох хууль тогтоомжид зайлшгүй хийх шаардлага амьдралаас урган гарч буйг энд зориуд цохон тэмдэглэхийг хүсэж байна.

Иймд манай улсын эрүүгийн хуульд цаашид нэг талын нэр төр гүтгэгдсэн гэх гомдол шаардлага нь эргэлзээтэй, нотлох баримт нь бүрэн бус бол хэнийг ч гүтгэлэг, доромжлолын эсрэг хуулиар ял шийтгэж болохгүйг тусгаж өгөх, няцааж байгаа зүйл нь худал ташаа болох нь нотлогдоогүй, санаатай хуурамчаар үйлдсэн буюу худал ташаа болохыг мэдсээр атал бодлогогүй мэдээлсэн эсвэл нөгөө талд зориуд хор уршиг учруулахаар тусгай зорилготой гүтгэж доромжилсон нь нотлогдоогүй бол гэмт хэрэгт тооцохгүй байх нь дэлхий нийтийн жишиг болсныг манай хууль тогтоогчид анхааралдаа авна гэдэгт найдаж байна.

Тэгвэл иймэрхүү төрлийн гомдол маргааныг шийдвэрлэхэд дараах арга замуудыг сонгож болох юм. Үүнд:

1. Иргэний хууль болон Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд бусдын нэр төр, алдар хүнд ажил хэргийн нэр хүндэд үндэсгүйгээр халдсан сэтгүүлчид бус, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд мөнгөн төлбөр оногдуулдаг болвол тэдгээрийн эзэд хариуцлагагүй сэтгүүлчийнхээ өмнөөс зэм хүлээхгүйн төлөө сэтгүүлчидтэйгээ, тэдний бичиж, нэвтрүүлж буй зүйлтэй ажиллах болно.
2. Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүр өөрийн ёс зүйн кодоо баталж үүгээрээ сэтгүүлч, сурвалжлагч нартайгаа хариуцлага тооцох механизмыг бүрдүүлэх шаардлагатай байна. Сэтгүүлчийн ёс зүйн кодоод зааснаар, нэр төрөө доромжлуулж гүтгүүлсэн гэх этгээд тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон сэтгүүлчтэй эвлэрч няцаалт хийх боломжийг илүү түлхүү ашиглах.

Энд нэгэн жишээг сонирхуулахад АНУ-ын “Нью-Йорк Таймс” сонин 2000 оны 12 дугаар сард “Бидний нэр алдрын дүрэм” хэмээх бодлогын баримт бичиг гаргасан бөгөөд түүндээ “Хэрэв “Нью-Йорк Таймс” сонин дээр хэн нэгэн хүнийг шүүмжилсэн нийтлэл гарвал шүүмжлүүлж байгаа этгээдэд нэр төрөө хамгаалах болон няцаалт өгөх боломжийг сонины зүгээс санал болгох ёстой”³ хэмээн бичжээ. Уг сонин 1998 онд “Бидний хамгийн их сүр хүч бол “Нью-Йорк Таймс” сонины нэр хүнд. Бид үүнийг гутаах, сүйтгэх ямар ч зүйлийг хийх ёсгүй, харин ч боломжийн хирээр тэрхүү нэр хүндийг дээшлүүлэх ёстой”⁴.

“Цензурын эсрэг!!!” дугуй ширээний уулзалтанд тавьсан илтгэл

ХЗДХЯ-ны дэд сайд Ш.Сүхбаатар.

³ «Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй» УБ 2002. 8 дахь талд

⁴ «Чөлөөт хэвлэл өөрийгөө өмгөөлөхүй» УБ 2002. 32 дахь талд

шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй” гэж заасан нь сэтгүүлчдийн цуглуулсан баримт яагаад ч нотлох баримт болж чадахгүйг давхар илтгэж байна. Дээр нь мөнөөх хуулийн 83 дугаар зүйлийн хоёрт “Хохирогч мэдүүлгийнхээ эх сурвалжийг зааж чадаагүй бол тэр нь нотлох баримт болохгүй” гэж заасан нь нэг талаасаа иргэд олон түмний өмнөөс хохирогч болж байгаа сэтгүүлч эх сурвалжаа зайлшгүй хэлэхээс нааш цуглуулсан аливаа зүйлс нь нотлох баримт болж чадахгүй нь ээ. Нөгөө талаас мөн хуулийн 95 дугаар зүйлийн хоёрт “Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүх нь ...нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ” гэж заасан нь сэтгүүлчдийн олж цуглуулсан баримт аль ч шатанд үнэлэмжгүй болж мэдэх нь ээ.

Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийг олж мэдэх боломжгүй, аливаа байгууллагын архивт орохын тулд заавал албан тушаалтнаас зөвшөөрөл авах шаардлагатай, сэжиг бүхий хүний хойноос асууж лавлах, дагаж танадах, хавь ойрын хүнээс тодруулах, зураг хөрөг таниулах зэрэг бүхий л үйлдэл нь хууль бус байгаа тохиолдолд яагаад ч нотлох баримт болж чадахгүй учраас өнөөдөр манайд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих ямар ч боломжгүй, хэрэв зоригловол манай сэтгүүлчдэд халгаатай байхаар байна.

Хэрэв одоо эрэн сурвалжлах сэтгүүл зүйн материал бичвэл манай сэтгүүлчид Эрүүгийн хуулиар хамгийн түрүүнд “доромжлох, гүтгэх” цаашилбал “Гүйцэтгэх ажлын хууль тогтоомжийг зөрчих”, “Хувь хүний нууцыг задруулах”, “Зориуд худал мэдээлэх” гэх мэт хэрэг үйлдсэн гэж, Иргэний хуулиар “Алдар хүндийг гутаасан” гэж ял зэм хүртэж эрүүгийн хуулийн хөнгөн, хүндэвтэр, хүнд заалтуудаар, иргэний хуулийн үлэмж хэмжээний торгууль шийтгэлээр яллуулах нөхцөл хүлээж байна.

Харин үүнээс гарах ганцхан зүйл заалт Эрүүгийн хуульд байна. Энэ нь Эрүүгийн хуулийн 42 дугаар зүйлийн хоёрдугаар хэсэгт байгаа “Энэ хуулиар хамгаалагдсан төр, нийгмийн ашиг сонирхол, өөрийн болон бусдын амьд явах эрх, халдашгүй чөлөөтэй байх, түүнчлэн бусад эрх, эрх чөлөөнд тулгарсан аюулыг зайлуулахын тулд энэ хуулийн тусгай ангид заасан

үйлдлийг хийж, учруулсан хохирол нь учирч болох байсан хохирлоос бага бөгөөд уг аюулыг тухайн нөхцөл байдалд өөр аргаар зайлуулах боломжгүй байсан бол уг үйлдлийг гэмт хэрэг гэж тооцохгүй” гэсэн заалт юм. Гэвч хууль хяналтынхан сэтгүүлчдийг энэ зүйл заалтад хамруулах нь юу л бол.

Эрүүгийн хуульд сэтгүүлчдийн үйл ажиллагаатай холбоотой ганцхан зүйл бий. Тэр нь “Сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийх” гэсэн зүйл бөгөөд доторх агуулга нь ердөө л “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсвэл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол...” албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх тухай заалт юм. Түүнээс биш сэтгүүлчийг өөрийг нь хамгаалсан ямар ч зүйл заалт Эрүүгийн хуульд байхгүй.

Олон нийтийн радио телевизийн хуульд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийтийн ашиг сонирхол хөндөгдсөн гэж шүүх ил болгохоос бусад тохиолдолд ОНРТ-ийн ажилтан мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж заасан нь нэг талаасаа нууцлах эрхтэй ч юм шиг, нөгөө талаасаа нууцлах ёсгүй ч юм шиг давхар утгыг агуулж байна. Тэгээд ч энэ нь Монголын нийт сэтгүүлчдийн хувьд мэдээллийн эх сурвалжаа нууцлах эрх зүйн чадамжгүй заалт юм.

Иймд юуны өмнө ойрын хугацаанд төр засгийн зүгээс эрх зүйн баримтад хэд хэдэн зүйлийг тусгах шаардлагатай байна.

Эрүүгийн хуульд “Сэтгүүлчид нотлох баримт цуглуулах эрхтэй. Сэтгүүлчид эх сурвалжаа нууцлах эрхтэй” гэх юм уу, эсвэл “Нийтийн эрх ашгийн төлөө хийсэн сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаа нь учирч болох байсан хохирлоос бага тохиолдолд гэмт хэрэг гэж тооцохгүй” гэсэн, Архивын тухай хуульд “Аль ч байгууллагын архив сэтгүүлч мэргэжлийн үнэмлэхээрээ үйлчлүүлэх эрхтэй” гэсэн заалтыг тус тус оруулах хэрэгтэй.

Авилгын тухай хуульд байгаа “Хөрөнгө орлогын мэдүүлэг нь хувь хүний нууц байна” гэсэн заалтыг хүчингүй болгох, Учир нь, авилгын хуулийн үйлчлэх хүрээ нь төр, засгийн өндөр дээд албан тушаалтнууд, төрийн өмчийн оролцоотой байгууллагын удирдах албан тушаалтнууд тул тэд татвар төлөгчдийн хөрөнгөөр ч үйл ажиллагаагаа явуулж байгаа учраас татвар төлөгчдөөс нуух зүйл байх учиргүй.

Энэ бүхнийг хууль эрхийн актуудад тусгасан тохиолдолд эрэн сурвалжлах сэтгүүл зүй хөгжих эрх зүйн орчин ямар нэгэн хэмжээгээр бүрдэх болов уу.

“Цэнзурын эсрэг!!!” дугуй ширээний уулзалтанд тавьсан илтгэл

“Ардын эрх” сонины сэтгүүлч Г.Энхбаатар



байгууллага, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн аль аль нь байх ёсгүй гэдэг нь тодорхой байна. Гэтэл өнөөдөр ажиглагддаг нэг ойлгомжгүй үзэгдэл нь төрийн байгууллага “гутаагдсан нэр төрөө” сэргээлгэхээр шүүхэд хандан нэхэмжлэл гаргадаг, бүр гэм хорын хохирол учирсан хэмээн үзэж мөнгөн төлбөр нэхэмжлэх явдал гардаг.

Иргэний хуулийн зөвхөн нэг заалтын хүрээнд эргэлдэхэд л иймэрхүү дүр зураг харагдаж байна. Өөр нэг маш бөөрөнхий хэн ч юу ч гэж тайлбарлаж болох ээдрээтэй зүйл заалт байдаг нь Иргэний хуулийн 511 дүгээр зүйл юм. 511 дүгээр зүйлд “511.1. Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол эд хөрөнгийн хохирол арилгасныг үл харгалзан, эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ. 511.2. Эдийн бус гэм хорыг арилгах хэмжээг мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох бөгөөд мэдээ тараасан уг хэлбэр болон бусад аргаар няцаалт хийхийг гэм хор учруулсан этгээдэд үүрэг болгоно” гэжээ.

- Энэхүү 511.2-т “...хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох...” гэсэн нь бас бэрхшээл болоод байгаа юм. Нэхэмжлэгч энэ заалтыг ашиглаад дурын тоог буюу хатуухан хэлэхэд амандаа багтсан, эсвэл өөрийнхөө мэддэг хамгийн их тоог хэлж мөнгө нэхэмжлэх явдал ажиглагддаг. Хэрвээ үнэхээр нэхэмжлэгчийн нэр төр гутаагдсанаас болоод түүнд хохирол учирсан бол түүнийг нь нөхөн төлөх нь зүйтэй гэдэгтэй маргахгүй. Гэхдээ учирсан хохирлын хэмжээ нь нотлох баримтаар нотлогдсоны үндсэн дээр тогтооход баймаар.
- Мөн нэхэмжлэгчийг гомдоосон мэдээлэл болон гэм хор учирсан хоёрын хооронд шалтгаант холбоо байх ёстой. Түүнийг нэхэмжлэгч тал өөрөө нотлох ёстой. Жишээлбэл, зодооны хэрэг дээр авч үзье. А нь Б-ийн хэвлийд гараараа цохисноос болж А-ийн тархи нь хөдөлсөн байж таарахгүй. Түүнтэй адил мэдээлэл, гэм хор хоёрын хооронд заавал шалтгаант холбоог нь тогтоосны үндсэн дээр гэм хорын хохирол гаргуулах ёстой баймаар. Гэтэл шүүх дээр тэр талыг огт тогтоолгүйгээр хэргийг шийдвэрлэдэг нийтлэг практик байна..

Сэтгүүлчдийг хэвлэн нийтэлсэн үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хэрэгт буруутгадаг тохиолдол бол Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хэд хэдэн төрлийн гэмт хэрэг

байдаг. Хамгийн түрүүнд ярих зүйл бол гүтгэх гэмт хэрэг буюу Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйл. Ер нь бол сэтгүүлчдийн эсрэг хэвлэн нийтлэх үйл ажиллагаатай нь холбогдуулан эрүүгийн хуулинд заасан хатуу чанга ял шийтгэл оногдуулах шаардлагагүй гэдгийг 2000 оны 12 сарын 01-нд батлагдсан НҮБ-ийн тунхаглалд “үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралд ороод байгаа ... нь сэтгүүлчид болон бусад хүмүүсийг дайран давшлах /цензурдэх/, гүтгэлэг доромжлолын хатуу хуулиар хохироох зэрэг хоёр хэлбэрийн түгшүүрээр илэрч байна” гэжээ. Эндээс харахад сэтгүүлчдийг хэвлэн нийтэлснийх нь төлөө эрүүгийн хэрэг үүсгэн ял шийтгэх байдлыг таслан зогсоохын тулд эрүүгийн хуулиас гүтгэх, доромжлох болон бусад төстэй заалтуудыг хасах шаардлагатай болов уу.

Одоогийн байдлаар нэгэнт хасаагүй байгаа болохоор байгаа хуулиа хэрхэн хэрэглэх тал дээр өөрийн ойлголтоо хэлэх нь зүйтэй болов уу. Эрүүгийн хуулийн 111 дүгээр зүйлд “111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол...” гэжээ. Эндээс харахад “...гутаах зорилгоор...” гэсэн нь гэм буруугийн шууд санаатай хэлбэрийг шаардсан байна. Шууд санаатай гэдгийг товчхоноор тайлбарлахад гэмт үйлдэлдээ хандсан сэтгэлзүйн хандлага буюу санаа зорилго. Санаа зорилго гэдэг бол гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал юм. Гүтгэх гэмт хэргийн гэмт хэрэг болдог шинж нь ямар зорилгоор уг мэдээг тараасан бэ гэдэгт байдаг. Өөрөөр хэлбэл, худлаа мэдээлэл тараасан тохиолдол болгон гүтгэх гэмт хэрэг болоод байж болохгүй шүү дээ. Тухайн мэдээлэл тараасан этгээд ямар зорилгоор уг мэдээллийг бэлтгэн тараасан байна вэ гэдгийг хэрэгт авагдсан нотлох



Далайд дусал

ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛИЙН ТҮҮХИЙГ БИЧИХ ЦАГ БОЛЖЭЭ

Хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан сэтгүүлчид бид хэдхэн хоногийн өмнө Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тэмдэглэн өнгөрүүлсэн. Ардчилсан, хүмүүнлэг, энэрэнгүй нийгэмд амьдарч байгаа гэж өөрсдийгөө цоллодог манай улсын хувьд хэвлэл мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжиж байгаа эсэх, Монголын анхны чөлөөт хэвлэлийн үүсэл, мөн сэтгүүл зүйн өнөөгийн чиг хандлагын талаар чөлөөт уран бүтээлч, сэтгүүлч Б.Галааридтай ярилцлаа.



Хэвлэл мэдээллийн эрх чөлөө гэж юу болохыг та тодорхойлохгүй юу?

Хэвлэлийн эрх чөлөө гэдэг ойлголт нь аливаа мэдээ, мэдээллийг ямар нэгэн хаалт, хяналтгүйгээр үнэн бодитойгоор олон нийтэд хүргэх үйл ажиллагаа гэж энгийнээр томъёолж болно. Ардчиллын эхэн үед үүнийг юу хүссэнээ бичиж болох хязгааргүй буюу **анархи** эрх чөлөө гэж ойлгох хандлага тухайн үеийн сэтгүүлчдэд ажиглагддаг байсан. Нэг намын үзэл сурталд захирагдсан хатуу хяналттай тоталитар эрх чөлөөнөөс салж байсан тэр үед бол энэ үзэгдэл гайхалтай зүйл байгаагүй. Харин сүүлийн жилүүдэд аливаа эрх чөлөө гэдэг нь бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагдсан, хариуцлагатай эрх чөлөө гэдгийг Монголын сэтгүүлчид бага багаар ойлгож байгаа.

Монголын анхны чөлөөт хэвлэлийн талаар?

Энэ талаар ярихад Монголын Ардчилсан холбоог үүсгэн байгуулагчдын нэг Дарь Сүхбаатарыг заавал дурдах ёстой. 1988 онд Дарь Сүхбаатар Улсын Багшийн Дээд сургуулийн оюутан байхдаа “Цагийн толь” нэртэй чөлөөт сонинг эрхлэн гаргасан. Нийт гурван дугаар гарсан энэ сонин нь нэг дугаар нь л гэхэд 500-1000 хувь хэвлэгдэн 1 төгрөгөөр борлуулагдаж байсан. Гэвч тухайн үеийн үзэл суртлын бодлогод таараагүйн улмаас МАХН-ын Төв хорооны даалгавраар Нийгмийг Аюулаас Хамгаалах цам энэ сонинг хаасан. Мөн МУИС-ийн оюутан Ш.Сүхбаатар 1989 онд оюутны “Эрдэм” сонинг гаргасан. Энэ сонин чөлөөт хэвлэлийн анхдагчдын тоонд зайлшгүй орох ёстой. Үүний дараа 1990 оны хавар Монголын Ардчилсан Холбоог дэмжигч С.Баяр тэргүүтэй хэсэг хүмүүс “Шинэ толь” нэртэй сонинг эрхлэн гаргасан. Энэ сонинг офсетээр хэвлэн гаргадаг байсан нь тухайн үедээ технологийн том дэвшил байсан. 1990 оны хавар “Ардчилал”, “Үг”, “Үндэсний дэвшил”, “Ертөнц” зэрэг шинэ сонинууд бий болсон. Эдгээр сонинууд хэдийгээр шинээр бий болсон нам, хөдөлгөөнүүдээс санхүүжиж, тэдний бодлого, зорилтыг сурталчилдаг байсан ч, чөлөөт хэвлэлийн хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан. Үүнээс гадна уран бүтээлчид сайн дураараа эвлэлдэн нэгдэж, сонин сэтгүүл гаргах явдал 1990 оны хавраас энгийн үзэгдэл болж хувирсан. Сэтгүүлч Т.Даваадорж, зураач Н.Чулуун нарын эрхлэн гаргадаг “Онигоо”-оос эхлээд бүр “Шүдний оо” гэж хүртэл нэртэй сонингуудыг тэр үеийнхэн гаргаж байсан. Тухайн үед сэтгүүлч С.Цогтсайхан, Г.Бадамсамбуу, Б.Эрдэнэбаатар, Ж.Мягмарсүрэн гээд олон сэтгүүлчид чөлөөт хэвлэлийн анхны дайчид болж нийгмийг сэрээх, сэхээрүүлэх үйлсэд асар их хувь нэмэр оруулсан. Ер нь Монголд чөлөөт хэвлэл анх үүссэн түүхийг үнэн бодитоор нь бичих цаг болчихоод байгаа шүү.

Чухам яагаад “Шинэ Толь” сонинг Монголын анхны чөлөөт хэвлэл гэж үздэг юм бэ?

“Шинэ толь”, “Цагийн толь” зэрэг сонин нь тухайн үед үзэл суртлын хориг сааданд авталгүй, олон ургальч үзлийг илэрхийлсэн мэдээ, мэдээлэл нийтлэхийг зорьж, нийтэлдэг

ч байсан нь “Монголын чөлөөт хэвлэлийн анхдагчид” гэх алдрыг зүй ёсоор хүртэх эрхтэй болгож байгаа юм. Нэг зүйлийг хэлэхэд, Монгол Улсын Боловсролын Их Сургуулийн Монгол Судлалын сургуулийн багш оюутнууд “Цагийн толь” сонинг сэргээн гаргахаар ажиллаж байгаад баяртай байна.

Тухайн үеийн хориг сааданд авталгүй мэдээ мэдээлэл нийтлэж байсан гэж байна л даа. Нийгэмд эрс өөрчлөлт хийсэн яг ямар нэртэй нийтлэл тухайн үед гарч байсан юм бол?

Тэр үед “Улс төр XXI зуун” гэж сонинд нийгмийн өөрчлөлтийн сэдвээр маш сайн нийтлэлүүд гардаг байсан. Мөн тэр үеийн сонинуудад ухуулга, уриалгын чанартай нийтлэл их гардаг байлаа. С.Цогтсайханы “Тарчлаан”, “Хонхны дуу” зэрэг нийтлэлүүдийн номууд тэр үед нилээд шуугиан тарьж байсан бичлэгүүдээс нь бүрдсэн байна лээ. С.Цогтсайхан бол шинэ үеийн сэтгүүл зүйн гол төлөөлөгч яахын аргагүй мөн. Мөн Баабарын нийтлэлүүдийг мартаж болохгүй. Өнөөдөр манай улсад хэвлэл мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжиж чадаж байгаа юу гэдэг асуудал дээр судлаачид болон мэргэжлийн хүмүүс маргалддаг л даа. Та үүн дээр ямар бодолтой байдаг вэ?

Монголд хэвлэлийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжиж байгаа гэдэг эргэлзээтэй л дээ. Яагаад гэвэл, хэдийгээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл харьцангуй олон болсон ч дийлэнх нь улс төр, бизнесийн тодорхой бүлэглэлүүдийн эрх ашгийг хамгаалдаг. Нэг үгээр хэлэхэд, захиалгат хэрэгслийн үүргийг л гүйцэтгэж байна. Нөгөө талаар Сэтгүүлчдийн мэдээлэл олж авах, түгээх боломж нь маш хязгаарлагдмал, энэ боломжийг олгох хууль эрх зүйн орчин нь бүрдээгүй гээд, олон хүчин зүйл хэвлэл мэдээллийн эрх чөлөө жинхэнэ утгаараа хэрэгжихэд саад болж байна. Тэгээд ч сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйгээ уланд аа гишгэж худалдагдах явдал түгээмэл болсноос чөлөөт хэвлэлийн нэр хүнд унаж байна. Та олон жил энэ салбарт ажилласан мэргэжлийн хүний хувьд Монголын өнөөдрийн сэтгүүл зүйн чиг хандлагыг тодорхойлбол?

Өнөөдөр манайд эздийн сэтгүүл зүй ноёрхож байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүссэн ч, хүсээгүй ч эзнийхээ, санхүүжигчийнхээ эрх ашгийг хамгаалахаас өөр аргагүй байдалд хүрч байна. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлэхийн тулд иргэний сэтгүүл зүйг хөгжүүлэх шаардлагатай. Манайхан иргэний сэтгүүл зүй гэдгийг арай л өрөөсгөл ойлгоод байх юм. Уг нь энэ бол иргэдийн оролцоог сэтгүүл зүйд бий болгохыг л хэлээд байгаа юм шүү дээ. Иргэний сэтгүүл зүйн гол онцлог нь илүү энгийн үг хэллэгтэй, уншигчдад ойр дөт, амьд байдаг явдал юм. Жинхэнэ олон нийтийн оролцоотой, иргэдийн хяналтан дор тэдэнд үйлчилдэг сэтгүүл зүй л манайд үгүйлэгдэж байна даа.

Баярлалаа. Таны уран бүтээлд амжилт хүсье.

Сэтгүүлч **Б.Насанжаргал**

Бүх улс орон өөрийн нутаг дэвсгэр дээр хэвлэмэл болон өргөн нэвтрүүлгийн хараат бус мэдээллийн хэрэгсэл байгуулах, үйл ажиллагаагаа чөлөөтэй явуулахыг зөвшөөрөх ёстой (Чөлөөт хэвлэлийн харти 2 дугаар зүйл).